



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/331

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.6, 17 дугаар зүйлийн 17.1.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. “Хүүхдийн эрхийг дээдэлье” Хүүхдийн эрхийг хамгаалах Олон улсын өдөрт зориулсан баярын нээлтийн нэгдсэн арга хэмжээний урлагийн тоглолтод оролцсон авьяаслаг хүүхдүүдийг урамшуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 6,191,000 (зургаан сая нэг зуун ерэн нэгэн мянга) төгрөгийг Эрх зүй нийгмийн хэв журам хөтөлбөрийн Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт хангах арга хэмжээний зардлаас гаргаж зарцуулахыг ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны.07.-р  
сарын.01.-ний өдрийн/24/-р захирамжийн  
хавсралт

ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ОЛОН УЛСЫН ӨДӨРТ  
ЗОРИУЛСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Арга хэмжээ	Хүүхдийн тоо	Мөнгөн дүн	Мөнгөн дүн
1	Гарын бэлэг	145	25,000	3,625,000
2	Хөнгөн хоол		17,700	2,566,000
		Нийт		6,191,000

\_\_\_оОо\_\_\_